

МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 12

№ 24/ТУЗ/10

Улаанбаатар хот

“Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай”

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10, 59.11 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.2, 64.4 дэх заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3, 2.5, 2.6 дахь заалт, 3 дугаар бүлэг, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. “Монложистикс Холдинг” ХК /цаашид “Компани” гэх/-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 14 цаг 00 минутад, зайнаас буюу цахим хэлбэрээр <https://hural.mlholding.mn> холбоосоор хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, нийтэд хүргэх хурлын зарыг хоёрдугаар хавсралтаар, санал авах хуудасны агуулгыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт авах саналыг урьдчилсан байдлаар болон хурлын үеэр <https://hural.mlholding.mn> холбоосоор хүлээн авч, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангаж ажиллахыг Тооллогын комисст үүрэг болгосугай.
5. Цахим хэлбэрээр урьдчилан санал авах болон саналын хуудсыг хүлээн авах хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл байхаар тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Гүйцэтгэх захирал Г.Хишигбатыг томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

1. Тооллогын комиссын дарга: Компанийн Дотоод аудитор Б. Тамжиддорж
 2. Тооллогын комиссын гишүүд: Компанийн Санхүүгийн шинжээч Б. Амарбаясгалан
Компанийн Нягтлан бодогч Н. Дэлгэрцэцэг
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
1. Зохион байгуулах комиссын дарга: Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Ц. Дуламсүрэн
 2. Зохион байгуулах комиссын гишүүд: Компанийн Захиргаа, захирлын туслах Э. Нарангарвуу
Компанийн хуульч Х. Хишигжаргал
Компанийн Маркетингийн менежер М.Хосбаяр
10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал, баримт бичигтэй танилцах боломжоор хангаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/ болон Хурал зохион байгуулах комисст тус тус үүрэг болгосугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичгийн жагсаалт, хурлын зар, санал авах хуудсыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийг баталж, Компаниас санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д зөвшөөрсүгэй.
13. Хурал хуралдуулах тухай энэхүү тогтоол болон хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох баримт бичгийн хамт Тогтоол гарсан өдрөөс хойш 3 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ц. Дуламсүрэн/-д үүрэг болгосугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
15. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Л. Ганзоригт/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГАНЗОРИГТ